

Боловсрол, соёл, урлагийн газрын 7 хоногт

хийсэн ажлын мэдээлэл

2018.04.12

№	7 хоногийн товч мэдээ	Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	Бусад асуудал
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх тухай 53 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн төвийн хүүхдийн цэцэрлэгүүдэд сарын аяныг хэрэгжүүлэх ажлыг эхэллээ.	Сар бүрийн эхний 7 хоногт багш, сурагчдаас авах түвшин тогтоох шалгалтын бэлтгэл ажил хангах.	
2	Өлгий сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн "Хүүхдийн хөгжилд багш ажилтны оролцоо"сэдэвт сарын аян зохион явуулав.	Өсвөрийн төгөлдөр хуурчдын Аймгийн уралдаан зохион байгуулах.	
3	Аймгийн хүүхдийн цэцэрлэгийн арга зүйч нартай хамт СӨБ-ын салбарт "Тогтвортой хөгжил-сургуулийн өмнөх боловсрол "зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийн хүрээнд зохион явуулах ажлууд болон цаг үеийн асуудлын талаар санаа бодлоо солилцов.		
4	<p>“Боловсролын салбар дахь ил тод байдал, эгэх хариуцлага” төслийн хүрээнд “Харилцан суралцъя” аймгийн чуулга уулзалт БСУГазрын сургалтын танхимд 2018 оны 4-р сарын 12-13-ний өдрүүдэд зохион байгуулагдав. Уг чуулганд аймгийн Засаг Даргын орлогч дарга А.Камелият, Өлгий сумын засаг дарга Бахытхумар, ЗДТГазрын боловсрол хариуцсан мэргэжилтэн Авжат, БСУГазрын Төрийн захиргааны нэгжийн дарга Р.Серикбол, гадаад хэлний асуудал хариуцсан мэргэжилтэн У.Ботакөз, Улаанхус, Баяннуур, Буянт, Толбо сумын Засаг дарга, хурлын дарга, сургуулийн захирлууд, сургуулийн эцэг-эх, багшийн холбооны төлөөлөл оролцов.</p> <p>Чуулганы явцад төсөл хэрэгжиж буй 4 Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар харилцан ярилцав.</p>		

--	--	--	--